



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/8/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Должмаа Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил Үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	14
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Бодо.од. 27 № 219

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

005020178



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.1. Оршил

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Д.Болормаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 26-наас 2020 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлж, аудит хийлгэх тухай хүсэлтийг 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 115 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эмнэлгийн эмч, мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, нийгмийн эрүүл мэндийн болон анхан шатны тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэж, хүн амын дундаж наслалтыг уртасгах”-д оршино.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төв нь 2019 оны үйл ажиллагааны чиглэлийг “Хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж эрт илрүүлэг хийх, эх, хүүхэд, жирэмсний хяналтыг сайжруулан анхан шатны тусламж үйлчилгээг чанартай, жигд хүргэх, нийгмийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр Эрүүл мэндийн боловсрол олгох эмч, мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахин “Инээмсэглэл-ээрэг, хандлага” уриатайгаар ажиллах” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 42 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзэж аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous 4.10, цалингийн Payroll" программ хангамж ашигладаг байна.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 38 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 26 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын

санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Их” гэж үнэлэн, зардлын дүн тэрбум төгрөгөөс дээш дүнтэй тул материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн үр дүнгийн тайлангийн нийт зардал 310806.9 мянган төгрөгөөс тооцон 6216.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 8843.2 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 2627.1 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөлтийн шатанд Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 он 03 дугаар улирлын санхүүгийн тайланг татсантай холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14433.7 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Энэ нь сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-
АВЛАГА	-	5,666.87	5,666.87
БАРАА МАТЕРИАЛ	46,097.79	57,856.03	11,758.25
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	647,415.38	621,473.63	(25,941.76)
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	(163,825.46)	(169,742.56)	(5,917.10)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	529,687.71	515,253.97	(14,433.74)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	4,191.68	4,191.68
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	529,687.71	511,062.29	(18,625.42)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	529,687.71	515,253.97	(14,433.74)

Тус байгууллага Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй оны эцэст 5666.8 мянган төгрөгийн авлага, 4191.6 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 11758.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 57856.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой аж ахуйн материал өмнөх оноос өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 25941.7 мянган төгрөгөөр буурч оны эцэст 621473.6 мянган төгрөг болсон нь сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.09.12-ны өдрийн 24 тоот тогтоолоор хөрөнгө акталсантай холбоотой байна.

Санхүүгийн тайланд эмийн тооцоог тухай бүр хийгээгүйгээс өмнөх оноос авлага 5666.8 мянга, өглөг 4191.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа тул цаашид эмийн тооцоог тухай бүр хийж, авлага, өглөгийг барагдуулах албан шаардлагыг өглөө.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 529687.7 мянган төгрөг болж 18625.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт 4 арга хэмжээний зардалд зориулан тусгай зориулалтын шилжүүлгээр 375859.1 мянга, орон нутгийн төсвөөс 16814.2 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 33571.4 мянган төгрөг авахаар батлагдсанаас тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн дэмжлэгийг бүрэн авч, харин Эрүүл мэндийн даатгалын сангаас 3303.0 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан ба оны эцэст 5372.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн нь орон тоо дутуугаас хэмнэгдсэн цалингийн зардлын хэмнэлт байна.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвд өөрийн орлогын төлөвлөгөө өгөөгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар “Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо”-ноос сорьц тээвэрлэлтийн зардалд 215.9 мянган төгрөг олгосныг тээврийн зардалд олгосон байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 44 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 23 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 38 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 10 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 28 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

№	Шийдэл	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал /сая.төг/		
		Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	4.2	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	29.9	
3	Албан шаардлага өгсөн	1	9.2	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	8	43.4	

Аудитаар нийт 43342.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 29979.2 мянган төгрөгийн 2 алдаанд төлбөрийн акт тогтоож, 9154.3 мянган төгрөгийн 1 алдаанд албан шаардлага өгч, 4208.5 мянга төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгснийг менежментийн захидалд тусгав.

Аудитаар дараах алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Тус байгууллагад анх 426404.7 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдаж, аймгийн Засаг даргын 2019.10.28-ний өдрийн А/560 тоот төсөвт зохицуулалт хийх захирамжаар багаж, техник хэрэгсэл худалдан авах зардалд 840.0 мянган төгрөг нэмж 427244. мянган төгрөгийн төсөв батлагджээ. Аймгийн Засаг даргын 2019.12.16-ний өдрийн А/645 тоот захирамжаар төсөвт зохицуулалт хийж, эмийн зардлыг 11420.0 мянган төгрөгөөр

нэмж, цалин, бараа үйлчилгээний бусад зардал, томилолт, шуудан холбооны зардлыг хассан байхад төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг 1500.0 мянган төгрөгөөр илүү буюу 428744.7 мянган төгрөгөөр гаргасан байсныг аудитаар залруулав.

2. Цалингийн цэст, нийгмийн даатгалын мэдээг тулган шалгахад нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 217.4 мянган төгрөг байхад тайланд НДШ-ийн авлагыг 431.5 мянган төгрөгөөр тусгаж, 217.0 мянган төгрөгөөр илүү тусгасан зөрчлийг аудитаар залруулав.

2.11.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.11.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг дутуу авснаас эмийн өр үүссэн шалтгаанаар оны эцэст эмийн зардлыг 11420.0 мянган төгрөгөөр нэмж тодотгосон атлаа хэмнэгдсэн эмийн зардлыг төсөвт төвлөрүүлэлгүй аймгийн Эрүүл мэндийн газрын эмийн тооцоонд 1298.7 мянган төгрөгийг шилжүүлж, нэмж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.2 Балансын данстай холбоотой асуудал

Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газрын Хаан банкны 5249116993 тоот дансанд 16206.9 мянган төгрөг шилжүүлсэн, бараа материалын тайланд 18 удаагийн зарлагын падаанаар тус газраас 10980.4 мянган төгрөгийн эм авч, 5226.5 мянган төгрөгийн авлагатай гарсныг баланст тусгасан боловч аймгийн Эрүүл мэндийн газартай тооцоо нийлсэн акт байхгүй байна. Аудитын явцад аймгийн ЭМГ-аас энэ асуудлыг тодруулахад эмийн санчаас авах авлага гэсэн тайлбарыг хийсэн бөгөөд сумын Эмийн сангийн эмийн санч, аймгийн ЭМГ-ын хооронд тооцоо нийлж, 4641.4 мянган төгрөгийн тооцоотой гарсан ба тайлангийн авлага 5222.5 мянган төгрөгийн авлага, эмийн сангийн ЭМГ-т төлөх өглөгийн зөрүү 581.1 мянган төгрөгийг эмийн санч өөрт байгаа эмийн үлдэгдлээс олгосон гэсэн тайлбарыг хийж байгаа болно.

“Баянхонгор хайрхан фарм” ОНӨААН-аас 17847.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл авч, 13919.3 мянган төгрөгийг шилжүүлж, 3927.7 мянган төгрөгийн өглөгтэй гарч, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан боловч Баацагаан сумын Эрүүл мэндийн төвөөс 2019.12.26-ны өдөр шилжүүлсэн 2125.4 мянган төгрөгийг аймгийн Эрүүл мэндийн газрын Хаан банкны дансанд шилжүүлсэн бөгөөд энэ талаар “Баянхонгор хайрхан фарм” ОНӨААН-ийн нягтлан бодогчоос тодруулсан боловч хариу ирүүлээгүй болно.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2.11.1.3. Балансын данстай холбоотой асуудал



Тус байгууллагыг шалгах явцад аймгийн Эрүүл мэндийн газар төсвөөс гадуур Хаан банканд байршуулсан дансаар эмийн үнийг дамжуулан авсан зөрчил илэрч, аудитаар тодруулан шалгахад 2019.12.31-ний өдөр тус дансны үлдэгдэл 28680.5 мянган төгрөгийг ХЛ75053102 регистрийн дугаартай хувь хүний данс руу шилжүүлсэн байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь “Банканд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-т заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аймгийн Эрүүл мэндийн газар, “Баянхонгор хайрхан фарм” ОНӨААН-тэй эмийн тооцоог тухай бүр хийгээгүй авлага, өглөгтэй гарсан, тооцоо нийлсэн актууд зөрүүтэй байгааг шалгах шаардлагатай байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баацагаан сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудаст оруулсан байдлыг шалгахад дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	11		
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	91	5	
	Нийт	27	151	146	5	-

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн тайланд “Глобал капитал” ХХК аудит хийж, зөвлөмж өгөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

2019 оны эхний 9 сарын байдлаар хийсэн завсрын аудитаар нийгмийн даатгалын мэдээг цалингийн цэсттэй тулган шалгахад байгууллагын жолооч Б.Түвдэндоржийн цалинг Нийгмийн даатгалын мэдээнд 296.4 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн алдаа илэрснийг залруулах зөвлөмж өгч, нийгмийн даатгалын мэдээнд залруулсан байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад 10 дугаар сард ээлжийн сувилагч Г.Нэргүйн 493041 төгрөгийн цалинг нийгмийн даатгалд мэдээлэхдээ 394433 төгрөгөөр буюу 98608 төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Байгууллагын даргын тушаалаар 2 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахдаа үндсэн цалинг бууруулаагүй, сахилгын шийтгэлийн бичилтийг буруу хийснээс цалингийн зардал санхүүгийн тайланд 709.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйл, Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны "Ажил олгогчийн НДШ-ийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрөл, код" тус тус зөрчсөн зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл: Цалингийн зардлыг үнэн зөв тайлагнаагүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Ажиллагсдын цалинг нийгмийн даатгалын мэдээнд үнэн зөв мэдээлж байх, Г.Нэргүйн дутуу мэдээлсэн цалинг нийгмийн даатгалын мэдээнд залруулж нөхөн мэдээлэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

3.2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл



3.2.1 Илрүүлэлт:

Байгууллагын дарга Д.Болормаад 2019.10.04-ны өдөр томилолтын зардалд 42.0 мянган төгрөг олгохдоо цалингийн зардлаас олгосон, "Хонгор ойл" ХХК-д шатахууны үнэнд 46.5 мянган төгрөгийг шилжүүлэхдээ хоолны зардлаас олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан зардлын ангиллыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Тээвэр шатахуун, нормативт зардлыг өөр зардлын ангилалд оруулж, буруу тайлагнах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг дагуу зардлыг бүртгэж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж, зардлыг өөр зардлаас зарцуулж гүйлгээ хийдэг явдлыг таслан зогсоох.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

3.3 Зарлагын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

"Могойн хөндий" ХХК-тай халаалтын гэрээ байгуулахдаа сард болон жилд төлөх мөнгөн дүнг гэрээнд тусгаагүй, 12 дугаар сард сар бүр төлдөг 1664113 төгрөгөөс нэхэмжилсэн байхад зардлын өглөгтэй байхад санхүүгийн тайланд өглөгийг тусгаагүй байна. Энэ талаар "Могойн хөндий" ХХК-ний нягтлан бодогч тайлбар өгөхдөө "Халаалтын зардалд төлөх дүнг дутуу авсан. Энэ нь байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд манайх дутуу төлбөрийг авахгүй гэж тохирсон" гэсэн хариу ирүүлсэн.

Энэ нь Үнэн зөв байдал, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Гэрээг дүгнээгүй байх, гэрээний дүнгээс илүү төлбөр олгох

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагуудтай гэрээ байгуулахдаа төлөх мөнгөн дүнг оруулж, гэрээг оны эцэст дүгнэж, үр дүнг тооцож байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

3.4 Зардлын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор орон нутгаас тогтмол зардлын санхүүжилтэд 16804.4 мянган төгрөгийг баталсан ба үүнээс тогтмол зардалд 13814.2 мянга, урсгал засварын зардалд 3000.0 мянган төгрөг зарцуулахаар баталжээ. Урсгал засварын зардалд батлагдсан зардлаас 1500.0 мянган төгрөгийн компьютер, 180.0 мянган төгрөгийн чагнуур,

даралтын аппарат, 778.0 мянган төгрөгийн аяга ариутгагч, дээж хадгалах хөргөгч, 467.0 мянган төгрөгийн аж ахуйн материал авч зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зардлыг хөрөнгө худалдан авахад зарцуулж зориулалт бусаар зарцуулахыг зогсоох.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

3.5 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.5.1 Илрүүлэлт:

Тус байгууллагад 450.0 мянган төгрөгийн программ, 6362.2 мянган төгрөгийн эмнэлгийн газар, 1630.0 мянган төгрөгийн эмчийн байрны газар бүртгэлтэй байна. Бараа материалын үлдэгдлийг шалгахад бусад хангамжийн материалд 16.0 мянган төгрөгийн архивын программ бүртгэлтэй байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС 12, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.1 заалтыг зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл:

Биет бус хөрөнгийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгахдаа буруу ангилж, бүртгэх, тайлагнах

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Архивын программын ашиглалтыг мэргэжлийн байгууллагаар тогтоож, цаашид ашиглахгүй тохиолдолд балансаас хасах

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор, нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	46,097,785.00	63,522,902.57
АВЛАГА	00.00	5,666,871.77
Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	217,432.08
Бусад авлага	00.00	5,449,439.69
Байгууллагаас авах авлага	00.00	5,373,709.69
Хувь хүмүүсээс авах авлага	00.00	75,730.00
БАРАА МАТЕРИАЛ	46,097,785.00	57,856,030.80
Түүхий эд материал	1,816,834.00	3,385,674.80
Эм боох материал	1,816,834.00	3,385,674.80
Хангамжийн материал	44,280,951.00	54,470,356.00
Бичиг хэргийн материал	678,760.00	436,390.00
Аж ахуйн материал	36,578,738.00	47,297,368.00
Хүнсний материал	1,159,043.00	440,538.00
Бусад хангамжийн материал	5,864,410.00	6,296,060.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	483,589,925.30	451,731,070.67
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	483,589,925.30	451,731,070.67
Биет хөрөнгө	475,597,725.30	443,738,870.67
Барилга, байгууламж, орон сууц	405,591,750.03	394,714,650.03
Хуримтлагдсан элэгдэл	-7,442,765.42	-19,814,575.50
Авто-тээврийн хэрэгсэл	49,768,600.00	41,036,434.00
Хуримтлагдсан элэгдэл	-17,474,613.89	-15,921,853.61
Машин тоног төхөөрөмж (компьютер)	142,875,423.96	136,425,327.96
Хуримтлагдсан элэгдэл	-125,574,509.49	-120,984,716.59
Тавилга, аж ахуйн эд хогшил	20,176,530.26	20,294,137.26
Хуримтлагдсан элэгдэл	-8,861,070.80	-7,439,237.25
Бусад үндсэн хөрөнгө	20,560,880.25	20,560,880.25
Хуримтлагдсан элэгдэл	-4,022,499.60	-5,132,175.88
Биет бус хөрөнгө	7,992,200.00	7,992,200.00
Бусад биет бус хөрөнгө	8,442,200.00	8,442,200.00
Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	529,687,710.30	515,253,973.24
НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	4,191,680.15
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	4,191,680.15
Өглөг	00.00	4,191,680.15
Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	173,885.00
Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	3,927,795.15
Бусад өглөг	00.00	90,000.00
Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	90,000.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	529,687,710.30	511,062,293.09
Засгийн газрын хувь оролцоо	529,687,710.30	511,062,293.09
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
	457,476,951.22	457,476,951.22
Өмч: - төрийн	457,476,951.22	457,476,951.22
Хуримтлагдсан үр дүн	-143,693,691.30	-162,319,108.51
Өмнөх үеийн үр дүн	-143,693,691.30	-143,693,691.30
Тайлант үеийн үр дүн	00.00	-18,625,417.21
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	215,904,450.38	215,904,450.38
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	529,687,710.30	515,253,973.24

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	411,590,755.00	423,535,770.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,178,211.00	00.00
Нийтлэг татварын бус орлого	26,178,211.00	00.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	26,178,211.00	00.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,178,211.00	00.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	62,224,644.00	47,288,670.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	323,187,900.00	376,247,100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	51,422,598.00	215,900.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,422,598.00	215,900.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	16,804,400.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	16,804,400.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,802,046.00	30,268,370.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	10,802,046.00	00.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	30,268,370.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	397,315,372.30	438,769,066.50
УРСГАЛ ЗАРДАЛ	397,315,372.30	438,769,066.50
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,351,918.30	433,396,205.86
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,524,941.00	277,173,939.00
Үндсэн цалин	220,524,941.00	277,173,939.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,729,236.00	34,510,561.28
Тэтгэврийн даатгал	18,240,377.01	23,980,760.28
Тэтгэмжийн даатгал	2,137,046.48	2,778,836.00
ҮОМШӨ-ний даатгал	1,810,288.63	2,223,070.00
Ажилгүйдлийн даатгал	431,067.54	499,660.00
Эрүүл мэндийн даатгал	4,110,456.34	5,028,235.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,216,739.00	13,555,444.64
Гэрэл, цахилгаан	1,498,916.00	1,902,173.64
Түлш, халаалт	13,563,423.00	11,364,871.00
Цэвэр, бохир ус	154,400.00	288,400.00
Хангамж, бараа материалын зардал	19,257,472.00	27,806,650.00
Бичиг хэрэг	1,690,747.00	3,011,300.00
Тээвэр, шатахуун	14,161,255.00	16,555,500.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	717,270.00	1,379,750.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,000.00	90,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,658,200.00	5,585,900.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	1,184,200.00
Нормативт зардал	28,718,239.00	36,532,007.02
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,159,094.00	29,055,802.02
Хоол, хүнс	5,559,145.00	7,476,205.00
Томилолт, зочны зардал	940,000.00	1,381,000.00
Дотоод албан томилолт	940,000.00	1,381,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,703,097.00	530,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,556,997.00	215,900.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	314,900.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	146,100.00	00.00
Бараа үйлчилгээний бусад зардал	29,262,194.30	41,905,803.92
Бараа үйлчилгээний бусад зардал	5,928,500.00	5,938,070.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,333,694.30	35,967,733.92
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,963,454.00	5,372,860.64

Бусад урсгал шилжүүлэг	52,839,444.00	00.00
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	10,802,046.00	00.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,037,398.00	00.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	124,010.00	00.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	124,010.00	00.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	08.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	08.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,372,852.64
Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,372,852.64
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	14,275,382.70	-15,233,296.50
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,316,695.48	3,392,120.71
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	3,392,120.71
Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	3,316,695.48	00.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-3,316,695.48	-3,392,120.71
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,958,687.22	-18,625,417.21

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	385,412,544.00	423,535,770.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,412,544.00	423,535,770.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	323,187,900.00	376,247,100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	51,422,598.00	215,900.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,422,598.00	215,900.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	16,804,400.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	16,804,400.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,802,046.00	30,268,370.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	10,802,046.00	00.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	30,268,370.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	385,412,544.00	423,535,770.00
УРСГАЛ ЗАРДАЛ	385,412,544.00	423,535,770.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	332,449,090.00	418,162,909.36
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,524,941.00	277,174,077.36
Үндсэн цалин	162,402,941.00	210,208,200.00
Нэмэгдэл	40,960,700.00	51,040,177.36
Урамшуулал	17,161,300.00	15,925,700.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,729,236.00	34,595,970.00
Тэтгэврийн даатгал	17,896,736.00	24,030,237.00
Тэтгэмжийн даатгал	2,208,100.00	2,801,240.00
ҮОМШӨ-ний даатгал	1,766,500.00	2,210,522.00
Ажилгүйдлийн даатгал	441,600.00	503,502.00
Эрүүл мэндийн даатгал	4,416,300.00	5,050,469.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,017,639.00	13,805,192.00
Гэрэл, цахилгаан	1,498,916.00	1,765,400.00
Түлш, халаалт	13,312,723.00	11,648,713.00
Цэвэр, бохир ус	206,000.00	391,079.00
Хангамж, бараа материалын зардал	16,153,455.00	21,270,242.00
Бичиг хэрэг	980,000.00	1,199,742.00

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАД ДҮГНЭЭТ

**Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Тээвэр, шатахуун	13,061,255.00	16,505,412.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	712,800.00	1,537,088.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,399,400.00	2,028,000.00
Нормативт зардал	31,196,986.00	39,595,828.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,188,746.00	31,897,398.00
Хоол, хүнс	6,000,000.00	6,052,430.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,008,240.00	1,646,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	4,449,500.00	7,324,200.00
Багаж, техник, хэрэгсэл	1,599,500.00	2,925,000.00
Тавилга	00.00	1,400,000.00
Урсгал засвар	2,850,000.00	2,999,200.00
Томилолт, зочны зардал	940,000.00	1,401,000.00
Дотоод албан томилолт	940,000.00	1,401,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,504,913.00	557,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,356,413.00	215,900.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	341,900.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,500.00	00.00
Бараа үйлчилгээний бусад зардал	7,932,420.00	22,438,600.00
Бараа үйлчилгээний бусад зардал	7,932,420.00	22,438,600.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,963,454.00	5,372,860.64
Бусад урсгал шилжүүлэг	52,839,444.00	00.00
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	10,802,046.00	00.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,037,398.00	00.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	124,010.00	00.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	124,010.00	00.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	08.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	08.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,372,852.64
Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,372,852.64
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,476,951.22	215,904,450.38	-143,693,691.30	529,687,710.30
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,476,951.22	215,904,450.38	-143,693,691.30	529,687,710.30
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	457,476,951.22	215,904,450.38	-143,693,691.30	529,687,710.30
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-18,625,417.21	-18,625,417.21
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,476,951.22	215,904,450.38	-162,319,108.51	511,062,293.09



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	323,188,200.00	323,092,677.00	427,244,700.00	417,947,009.36
УРСГАЛ ЗАРДАЛ	323,188,200.00	323,092,677.00	427,244,700.00	417,947,009.36
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	323,188,200.00	323,092,677.00	427,244,700.00	417,947,009.36
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,525,800.00	220,524,941.00	283,730,500.00	277,174,077.36
Үндсэн цалин	162,403,800.00	162,402,941.00	210,208,200.00	210,208,200.00
Нэмэгдэл	40,960,700.00	40,960,700.00	57,596,600.00	51,040,177.36
Урамшуулал	17,161,300.00	17,161,300.00	15,925,700.00	15,925,700.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,786,700.00	26,729,236.00	35,466,300.00	34,595,970.00
Тэтгэврийн даатгал	17,954,200.00	17,986,736.00	24,117,100.00	24,030,237.00
Тэтгэмжийн даатгал	2,208,100.00	2,208,100.00	2,837,300.00	2,801,240.00
ҮОМШӨ-ний даатгал	1,766,500.00	1,766,500.00	2,269,800.00	2,210,522.00
Ажилгүйдлийн даатгал	441,600.00	441,600.00	567,500.00	503,502.00
Эрүүл мэндийн даатгал	4,416,300.00	4,416,300.00	5,674,600.00	5,050,469.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,024,400.00	15,017,639.00	13,814,200.00	13,805,192.00
Гэрэл, цахилгаан	1,505,000.00	1,498,916.00	1,765,400.00	1,765,400.00
Түлш, халаалт	13,312,900.00	13,312,723.00	11,648,800.00	11,648,713.00
Цэвэр, бохир ус	206,500.00	206,000.00	400,000.00	391,079.00
Хангамж, бараа материалын зардал	16,153,500.00	16,153,455.00	21,270,500.00	21,270,242.00
Бичиг хэрэг	980,000.00	980,000.00	1,200,000.00	1,199,742.00
Тээвэр, шатахуун	13,061,300.00	13,061,255.00	16,555,500.00	16,505,412.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	712,800.00	712,800.00	1,515,000.00	1,537,088.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,399,400.00	1,399,400.00	2,000,000.00	2,028,000.00
Нормативт зардал	31,215,900.00	31,196,986.00	42,898,600.00	39,595,828.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00	32,982,700.00	31,897,398.00
Хоол, хүнс	3,015,900.00	3,008,240.00	6,900,000.00	6,052,430.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	3,015,900.00	1,646,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	4,450,000.00	4,449,500.00	7,325,000.00	7,324,200.00
Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,600,000.00	2,925,000.00	2,925,000.00
Тавилга	2,850,000.00	2,850,000.00	1,400,000.00	1,400,000.00
Урсгал засвар	00.00	00.00	3,000,000.00	2,999,200.00
Томилолт, зочны зардал	950,000.00	950,000.00	1,401,000.00	1,401,000.00
Дотоод албан томилолт	950,000.00	950,000.00	1,401,000.00	1,401,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	148,500.00	148,500.00	400,000.00	341,900.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	400,000.00	341,900.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,500.00	148,500.00	00.00	00.00
Бараа үйлчилгээний бусад зардал	7,933,400.00	7,932,420.00	20,938,600.00	22,438,600.00
Бараа үйлчилгээний бусад зардал	7,933,400.00	7,932,420.00	20,938,600.00	22,438,600.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	323,188,200.00	323,092,677.00	426,244,700.00	417,947,009.36
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	323,188,200.00	323,092,677.00	375,859,100.00	370,874,247.36
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	323,188,200.00	323,092,677.00	375,859,100.00	370,874,247.36
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,024,400.00	15,017,639.00	16,814,200.00	16,804,392.00
Орон нутгийн төсвөөс	15,024,400.00	15,017,639.00	16,814,200.00	16,804,392.00

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	33,571,400.00	30,268,370.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00	33,571,400.00	30,268,370.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	25.00	25.00
Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00	20.00	20.00
Үйлчлэх ажилтан	04.00	04.00	04.00	04.00
ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	00.00	384.00	00.00	389.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00	25.00	25.00
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19.00	19.00	19.00	19.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00	06.00	06.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	215,900.00
УРСГАЛ ЗАРДАЛ	215,900.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	215,900.00
Бараа үйлчилгээний бусад зардал	215900.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	215,900.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	215900.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	215,900.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	215,900.00

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР



Б.ДОЛЖМАА

Огноо: 2020.02.27

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР



А.ЦЭЭНЯМ

Огноо: 2020.02.27

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.27

